



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 615

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаах авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Хил хамгаалах ерөнхий газар) бий болсон 2,504,900,000.00 (хоёр тэрбум таван зуун дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийн үнэ бүхий цэргийн байрыг хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн 0253 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Х.Лхагвасүрэн, Хилийн цэргийн 0253 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Нямбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, бүртгэлд тусгах асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль, тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002595

28-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
675 дугаар тогтоолын хавсралт

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬА ХИЛИЙН ЦЭРГИЙН 0253 ДУГААР АНГИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хүчин чадал		Үзүүлэлт	Хөрөнгийн балансын үнэ (төгрөг)
			хэмжих нэгж	Биет хэмжээ		
1	Хилийн цэргийн 0253 дугаар ангийн Цэргийн штабын барилга	7/17/2024	мкв	1020	Багана, суурь бүрэн цутгамал, шилэн фасадтай зоорийн давхартайгаа нийлээд 3 давхар барилга	2,504,900,000.00
Нийт дүн						2,504,900,000.00
(хоёр тэрбум таван зуун дөрвөн сая есөн зуун мянга)						